

**ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 5.1.1.1-д “авлигатай тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох...” гэж, 5.1.1.8-д “шударга ёсны үзэл санаа нийгэмд төлөвшиж, иргэн өөрт учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлдэг байх нийгмийн сэтгэлгээ, хандлага өөрчлөгдсөн байх;” гэж, 5.2.5-д “улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг шалгах, мэдээлэгчийг хамгаалахад иргэн хяналт тавих бололцоо бүрдсэн байх;” гэж, 5.2.7-д “авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, хяналт сайжирсан байх;” гэж тус тус тусгасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичгийн Тавдугаар бүлгийн “Авлигагүй засаглал” хэмээх зорилтын 5.6.5-д “Авлига, албан тушаалын гэмт хэргийн мэдээлэл хүлээн авах, нууцыг хадгалах тогтолцоог бэхжүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илчилсэн, мэдээлсэн хүнийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, олон нийтийн хяналтыг сайжруулна.” гэж мэдээлэгч, илчлэгчийн эрх зүйн орчныг нарийвчлан зохицуулах талаар тусгасан байна. Дээрх бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 120 дугаар захирамжаар авлига, хүнд суртлыг таслан зогсоох замаар авлигын индексийг бууруулах эрчимжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 92 дугаарт Монгол Улсын Засгийн газар Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулахаар тусгасан.

Монгол Улс Нэгдсэн Үндэсний байгууллагын Авлигын эсрэг конвенцид 2005 онд нэгдэн орж, Улсын Их Хурлаар соёрхон баталсан. Тус конвенцын 33 дугаар зүйлд “Оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийн талаарх аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс, үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалахаар заах талаарх зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэн оруулах асуудлыг авч үзнэ.” гэж тунхагласан. Монгол Улс гишүүн орны хувьд мэдээлэгч, илчлэгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх үүргийг хүлээж байгаа юм.

1.2.Практик шаардлага

Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд ил болгосныхоо төлөө тодорхой хувь хүн, бүлэг этгээд, аж ахуйн нэгж, албан тушаалтан, засаг захиргааны зүгээс ямарваа дарамт шахалтад өртөх, эрх чөлөөгөө хязгаарлуулах, хувь хүний эрх нь зөрчигдөх, хүчирхийлэлд өртөх улмаар үйл ажиллагаагаа хэвийн явуулж чадахгүйд хүрэх тохиолдол дэлхий нийтийн хэмжээнд байсаар байна.

Олон улсын судалгаанаас үзэхэд хувийн хэвшлийн салбарт үйлдэгдсэн залилангийн хэргийн 45 орчим хувийг салбар дотроос мэдээлсэн мэдээлэлд тулгуурлан илрүүлсэн байдаг. Зохисгүй үйлдэл, гэмт үйлдлийг дотооддоо мэдээлэх буюу шүгэл үлээх боломжийг бүрдүүлж, хөхиүлэн дэмжихийн ач холбогдолыг эндээс харж болно.

Монгол Улсын хувьд 2002 болон 2016 онуудад Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баталж мөрдүүлсэн хэдий ч шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна. Тодруулбал, Транспэрэнси интернэшнл байгууллагаас ази, номхойн далайн бүс нутгийн 20 гаруй мянган хүмүүсийн дунд авлигын талаар судалгаа зохион байгуулж “авлигын эсрэг иргэд тэмцэх хамгийн үр дүнтэй алхам юу вэ?” гэсэн асуултад тэдний ихэнх хувь нь “мэдээлэх”, мөн “хахууль өгөхгүй байх” гэж хариулсан байна. Улмаар уг судалгаагаар яагаад “мэдээлэх” буюу шүгэл үлээх алхмыг хийгээгүй шалтгааныг тодруулахад “үр дагавраас айдаг” гэж хариулсан байна.

Нийтийн ашиг сонирхлын төлөө ажилласныхаа төлөө амь нас, бие махбодод нь халдахаар заналхийлэх, нэр төр, алдар хүндэд халдах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, цахим хэлбэрээр халдлагад өртөх, мэдээлэл авах боломжийг хязгаарлах, мэдээлэл өгөхөөс татгалзах, үйл ажиллагааг нь үгүйсгэх, үл ойшоох, төвөгшөөх, төрийн байгууллагын зүгээс хүнд суртал гаргах, ялгаварлах, шударга бус хандах, цалин, нийгмийн халамжийг хязгаарлах, ажлаас халах, ажлын байрны дарамт үзүүлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах зэрэг хүндрэл бэрхшээл тулгарч байна. Хүний эрх, нийгмийн шударга ёсны төлөө дуугарсан хүмүүсийг дуу хоолойг хаахыг оролдох, цахим орчинд үг хэлээр дайрч, доромжлох, сүрдүүлэх, нэр төрийг гутаах, хууль шүүхийн байгууллагад дуудаж дарамтлах, сүрдүүлэх байдал сүүлийн жилүүдэд манай улсад ихээр гарах болсон.

Иймд Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг шүүмжилсэн, мэдээлсэн, илчилсэн тохиолдолд яллах, эрүүгийн хариуцлагад татах, дарамтлахаас мэдээлэгчийг хамгаалах, шүгэл үлээгчдийг аливаа өш хонзон, гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох үүднээс уг хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь 5 бүлэгтэй байна.

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тогтооно.

Хуулийн төслийн зорилтод нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээх нөхцөлийг бүрдүүлэх, шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах, урамшуулах, түүний эрх зүйн байдлыг дордуулсан шинжтэй аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгана.

Хуулийн төслийн үйлчлэх хүрээ нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэнд, байгаль орчин, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, шударга өрсөлдөөнийг дэмжих талаар нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн этгээдийн эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдсон харилцаанд үйлчлэх бөгөөд хамрах хүрээний хувьд иргэн, төрийн байгууллага, хуулийн этгээдэд үйлчилнэ.

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт шүгэл үлээх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, энэ хүрээнд шүгэл үлээх хэлбэр, үйл ажиллагааг тодорхойлох холбогдох байгууллага шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх, хяналт шалгалт явуулах, хяналт шалгалт явуулахаас татгалзах зэрэг шүгэл үлээгчийн мэдээллийг хянан шийдвэрлэх процессыг нарийвчлан тусгана.

Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт шүгэл үлээгчийн баталгаа буюу хувь хүний нууц, аюулгүй байдал, түүнд хуулиар шүгэл үлээхтэй холбогдуулан олгогдох эрхийг хангах талаар шүгэл үлээгчийн мэдээлэлд хамаарах асуудлыг хариуцсан холбогдох төрийн захиргааны байгууллагын эрх, үүргийг тогтооно.

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт шүгэл үлээгчийг нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсний төлөө дэмжих, урамшуулах тогтолцоог бүрдүүлж, түүнд олгох мөнгөн урамшуулал, нөхөн төлбөрийн хэм хэмжээг нарийвчлан тусгана.

Хуулийн төслийн тавдугаар бүлэгт шүгэл үлээх үйл ажиллагаанд хориглох зүйл, түүнтэй холбогдуулан гарах зардлын санхүүжилт, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Иргэдэд тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас түргэн, шуурхай үйлчилгээ авах боломж бүрдэж, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг хянах хүний эрхийг хангах, эрх тэгш нөхцөл байдлыг хангах, урамшуулах, хамгаалах нэгдсэн тогтолцоотой болно. Ингэснээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч иргэдийн эрх зөрчигдөхөөс сэргийлэх, төрийн үйл ажиллагаанд итгэх нийгмийн итгэл дээшилнэ.

Нэгдүгээрт, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэхэд чухал алхам болно.

Хоёрдугаарт, нийгэмд үүсээд байгаа авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, шударга ёсыг бэхжүүлэхэд чухал алхам болно.

Гуравдугаарт, Монгол улс нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт санхүүжилт шаардлагагүй болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Авлигын эсрэг хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд энэхүү хуулийн төсөлтэй холбогдуулан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсруулна.

---o0o---